



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 09 сарын 16 өдөр

Дугаар А/55

Мандалговь

“Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэдтэй
ажиллах арга зүй”-н сургалт зохион байгуулах тухай

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.2, 18.2.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэдтэй ажиллах арга зүй”-н сургалтыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, сургалтын хөтөлбөрийг 2 дугаар, шаардагдах зардлыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сургалтыг чанартай зохион байгуулж, хэрэгжилтийг хугацаанд нь тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Цэцэг), гишүүдэд үүрэг болгосугай.

3. Үйл ажиллагаанд шаардагдах 3 056 600 (Гурван сая тавин зургаан мянга зургаан зуу) төгрөгийн зардлыг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2020 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Цэцэг)-т даалгасугай.

ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

431190111